

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ЭМЧ, ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НЭР ТӨРД ХАЛДАХ АСУУДЛААРХ БУСАД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛДЭГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

Лавлагаа мэдээлэл

Судалгааны код: СТ-18/402

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Нэр төрийн халдашгүй эрх

Ашигласан материал

2. Эмчийн ёс зүй болон тусгай зөвшөөрөл

2.1. Гиппократын болон Женевийн тангараг

2.2. Анагаах мэргэшлийн зөвшөөрлийн бичиг (апробаци)

ХОЁР. БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Эрүүл мэндийн салбарын эмч ажилтны нэр төрд халдах асуудлаарх олон улсын хууль эрх зүйн зохицуулалтын нийтлэг жишиг

- АВСТРИ
- ЛИХТЕНШТЕЙН
- ХБНГУ
- БНСУ
- ЯПОН
- ШИНЭ ЗЕЛАНД
- БНЭУ
- ТАЙЛАНД
- МОНГОЛ УЛС

Судалгааны хураангуй

Монгол Улсын хүний эрхийн чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нэр төр, алдар хүндийн халдашгүй байдал гэж аль алиныг нь нэрлэн зааж, хамгаалалтад авсан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт тунхагласан халдашгүй эрхийн хүрээнд нэр төрийн халдашгүй байдлыг нэрлэн заасан бөгөөд Иргэний хуулиар илүү өргөн хүрээнд зохицуулсан байдаг.

Жам ёсны эрхийн онолын үүднээс хүний нэр төрийн халдашгүй эрх гэдэг нь хүн бүр ямар ч нөхцөл байдалд, элдэв ялгаваргүйгээр өөртэй нь бие хүний хувьд угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэн хүнлэг ёсоор хандах мөн чанарыг агуулж байдаг.

Нэр төр, алдар хүнд нь иргэний эрх зүй болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн судлагдахуун болохын хувьд Иргэний хуулийн 20, 21 дүгээр зүйлд “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах” тухай заасан. Энэ зүйлээр:

- иргэний нэр;
- нэр төр;
- алдар хүнд;
- ажил хэргийн нэр хүнд гэх 4 тусдаа ойлголтыг хуулиар хамгаалсан. Эдгээр ойлголтууд нь өөр хоорондоо нягт уялдаатай боловч бие даасан агуулгатай байна. Нэр төр, алдар хүнд нь иргэнд хамааралтай байдаг бол ажил хэргийн нэр хүнд нь иргэн, хуулийн этгээдийн аль алинд хамааралтай ойлголт.

Иргэний нэр: Иргэн өөрийн нэртэй байх явдал нь иргэний салшгүй эрх юм. Нэр гэдэг нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан, хүн төрснөөр түүнийг бодьгалжуулж буй нэгэн төрөл элемент юм. Иргэн нэртэй байхыг иргэний хуулиар хүлээн зөвшөөрч байгаа нь түүнийг эрх зүйн харилцаанд оролцох нөхцөлийг хангадаг. Иргэний нэрийг хууль бусаар ашиглах нь тухайн иргэний өөрийн нэрээр олж авсан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд сөрөг үр дагаврыг бий болгодог тул хуулиар хамгаална.

Нэр төр: нэр төр нь иргэний зан суртахуун, ёс зүй, ажил үйлс, мэргэжлийн шинжийн талаарх эерэг үнэлгээ юм.

Алдар хүнд: Алдар хүнд нь нэр төртэй салшгүй холбоотой ойлголт юм. Алдар хүнд нь тухайн иргэнд нийгэм, найз нөхөд, хамт олон, бусад харилцагч, түншлэгчээс өгч байгаа үнэлгээнд үндэслэсэн тухайн иргэний өөрийнх нь хувийн үнэлэмж юм.

Ажил хэргийн нэр хүнд: Энэ нь нийгэм-эдийн засгийн харилцаанд оролцогч хувь хүн, хуулийн этгээдэд хамааралтай ойлголт бөгөөд тухайн этгээд ажил мэргэжлийн болон албан тушаалын үүрэг, гэрээгээр хүлээсэн үүрэг болон бусад үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас шалтгаалан үүсэх үнэлэмж юм. Хувь хүн болон хуулийн

Улаанбаатар
2018 он

этгээд нь эдгээр үүрэгтээ шударга хандаж, түүнийгээ хэрэгжүүлж байвал ажил хэргийн нэр хүнд тогтвортой байдаг.

Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэдэгт:

- бодит байдалд нийцэхгүй мэдээлэл тараах;
- ийм мэдээллийг өөр хэн нэгэн этгээдэд дамжуулан мэдээлсэн байхыг ойлгоно.

Ийм мэдээ, мэдээллийг иргэнд өөрт нь мэдээлснийг гутаасан гэж үзэхгүй бөгөөд уг мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, электрон шуудангаар, хурал цуглаан дээр, мөн тухайн иргэний ажлын байран дээр тараасан, ажил байдлын тодорхойлолт, өргөдөл, албан тоотоор буюу амаар өөр этгээдэд хүргэсэн байхыг ойлгоно.

Түүнчлэн, бодит байдалд нийцсэн, үнэн мэдээлэл боловч хувь хүний нууцад хамаарах мэдээллийг иргэний өөрийн зөвшөөрөлгүй нийтэд тараасан бол нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж үзнэ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГААНЫ АЛБА